



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/82

Бодь

**Үер усны аюулаас урьдчилан
сэргийлэх чиглэлээр авах зарим арга
хэмжээний тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дгүээр зүйлийн 59.1.1, аймгийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/449 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Хур борооны улирал эхлэж гэнэтийн аадар борооны улмаас томоохон гол нуур, гуу жалаг, судаг дагаж үер буух эрсдэл өндөр байгаа тул үер усны ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг аймгийн Онцгой байдлын газраас баталсан нэгдсэн удирдамжийн дагуу 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл зохион байгуулсугай.

2.Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд, сэрэмжлүүлэг мэдээг шат дараатай хүргэж зохион байгуулж ажиллахыг Шуурхай Штабын ахлах (Н.Сумъяа), багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Сумъяа)-д даалгасугай.


ДАРГА



Р.БАТЖАРГАЛ

642201155

Сумын Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 01 өдрийн
~~02~~ дугаар захирамжийн хавсралт



ҮЕР, УСНЫ ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА
 ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2022 оны 07 дугаар сарын 01

Бодь

№	Хийх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Онцгой байдлын газраас бэлтгэсэн шторкыг нийт ард иргэдэд цахим сайтаар хүргэх	Өдөрт 3 удаа	Сумын Онцгой комисс, багийн Засаг дарга нар
2	Цаг уурын байгууллагаас үер усны аюулын талаар ирүүлсэн сэрэмжлүүлэг мэдээг иргэд олон нийтэд хүргэх	Өдөрт 1 удаа	Сумын Онцгой комисс, багийн Засаг дарга нар, Ус цаг уурын ажилтан
3	Томоохон гол, мөрөн, нуур, цөөрмийн дагуу хамтарсан эргүүл хийж амарч зугаалж буй иргэдэд сэрэмжлүүлэг, мэдээлэл өгөх	7 хоног бүр	Сумын Онцгой комисс, Цагдаагийн тасаг
4	Хүн ам олноор цуглардаг үйлчилгээний газруудад ухуулах хуудас байршуулах	7 хоног бүр	Засаг даргын Тамгын газар
5	Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх	7 сард	Засаг даргын Тамгын газрын Гамшгийн аюулаас хамгаалах ажилтан
6	Голын ай сав, гуу жалга, үерийн усны буулт бүхий газраар нутаглаж, суурьшсан айл өрхөд нүүлгэн шилжүүлэх тухай шаардах хуудсыг хүргүүлэх	07 дугаар сард	Багийн Засаг дарга нар, Цагдаагийн тасаг
7	Үер, усны аюулаас сэрэмжлүүлэх самбарыг эрсдэл өндөр газруудад байрлуулах	07 дугаар сарын эхний хоног	Сумын Онцгой комисс, Цагдаагийн тасаг
8	Хуучирч муудсан тэмдэг, тэмдэглэгээг солих	07 дугаар сард	Сумын Онцгой комисс, Цагдаагийн тасаг
	Нэгдсэн арга хэмжээний хүрээнд 3 удаа өдөрлөг зохион байгуулах	07 дугаар сарын 05, 28, 08 дугаар сарын 04	Засаг даргын Тамгын газар